



## Үүсгэн байгуулагчийн бодрол

### Бусдын ачийг хариулахуй

Би 88 насныхаа төрсөн өдрийг улс орны өнцөг булан бүрээс ирсэн гишүүдтэйгээ тэмдэглэж байхдаа гишүүд өөрсдийн олсон аз жаргалаа баяр хөөртэйгөөр инээмсэглэн өгүүлж байхыг хараад хамгаас илүү баярласан. Энэ нь надад бусдыг аз жаргалтай болгохын баяр хөөрийг дахин шинээр мэдрүүлсэн билээ.

Миний төрсөн нутаг жилийн бараг тэн хагаст нь 3 метр орчим зузаан цасанд дараастай байдаг бөгөөд тосгоны иргэд ч тэр их цасан дунд бие биедээ туслан амьдардаг байлаа. Манайх ам бүл 12 өнөр өтгөн гэр бүл хэдий ч хоорондоо муудалцаж маргалдана гэж үгүй. Бурханд залбирахын чухлыг зааж өгсөн бага сургуулийн захирал багш болоод сургаал номоор дамжуулан учирсан тоолж баршгүй олон хүмүүсийн ачаар өнөөгийн би бий болсон юм.

“Бусдаас авсан ач тусыг нэг бүрчлэн тоочоод үзэхэд буцаан хариулж чадсан нь хичнээн өчүүхэн бага юм бэ гэж өөрийн эрхгүй бодогддог” гэж хүмүүс ярьцгаадаг.

Уулын чинээ ач тусыг хүртэн амьдарч байгаагийн хувьд нэг өдөр ч болтугай илүү амьдарч хүмүүсийн ач тусыг хариулахгүй бол болохгүй гэж би өдөр бүр боддог юм.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, Х98-99

Living the Lotus  
Vol. 194 (2021.11)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа  
Эхийг хянасан: Монголын РКК,  
Мөнхцэцэг  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон  
улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-  
international@kosei-kai.or.jp

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*



## *Ерөнхийлөгчийн айлдвар*

### Өөрийгөө эргэцүүлэхүйн учир

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо

#### Өөрийгөө эргэцүүлэн бодох нь өөдөө тэмүүлэх сэтгэлийн илрэл

Дорнын нэрт сэтгэлгээ судлаач Ясүока Масахиро гуай “Хүн төрөлхийн эрхэм дээд, агуу гайхамшигт оршихуй руу ойртохыг тэмүүлж байдаг ба бурхан тэнгэрийг хүндлэн дээдлэх сэтгэл тэндээс бий болдог” гэсэн байдаг. Мөн хүн өөрөө ч гэсэн өсөж дэвшихийг зорьдог тул дутуу дулимаг өөрийгөө олж харахаар ичиж санаа зовох сэтгэл төрдөг ажээ. Өөрөөр хэлбэл өөрийгөө эргэцүүлэн бодож, алдаагаа ухааран гэмших сэтгэл нь хүмүүний сэтгэлийг хөгжүүлээд зогсохгүй бүр хүн төрөлхтний хөгжил дэвшилд шууд нөлөөлсөөр ирсэн гэсэн үг юм.

Гэвч энгийн нийгэмд өөртөө дүгнэлт хийж, алдаа дутагдлаа нуулгүй хэлж гэмшихийг өөрийгөө доош нь хийсэн үйлдэл мэтээр ойлгох нь их. Ялангуяа “гэмших, наминчлах” гэдгийг толь бичигт “Үйлдсэн гэм нүглээ ухаарч, түүнийгээ бурхан тэнгэр, хүмүүсийн өмнө шударгаар хэлж, өөрийгөө засаж залруулахаа амлах үйлдэл” гэж тайлбарласан байдгаас энэ үгийг сөрөг, бараанаар төсөөлдөг. Тиймээс алдаагаа ухаарч, хүний өмнө гэмшиж буйгаа илэрхийлэх нь ичгэвтэр, хөөрхийлөлтэй үйлдэл гэж бодох хүн байхыг үгүйсгэхгүй.

Гэхдээ өөртөө дүгнэлт хийж, алдаагаа ухааран гэмших сэтгэл нь өөрийн үлгэр дуурайл нэгэн хүн шиг болохыг эсвэл хүний хувьд өсөж хөгжихийг эрмэлзэх сэтгэлээс бий болдог гэж үзвэл өөрийгөө эргэцүүлэн бодож гэмших нь урагш тэмүүлэх эерэг хандлагын нэгэн илрэл юм. Энд өрөвдөлтэй хөөрхийлөлтэй зүйл огтхон ч байхгүй. Харин ч хүн гэдэг алдаж онож, бүтэлгүйтэж, түүнээсээ ичиж санаа зовонгоо улам бүр өсөж хөгждөг жамтай бус уу.

Бидний сайн мэдэх Лянхуан Гурамсан Сударын дүгнэлт судар болох Иж бүрний билигт бодисадвагийн даяны бүтээл сударт Цагаан лянхуа судрын сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэхэд шаардлагатай “наминчлах үйл”-ийн талаар голчлон айлдсан байдаг. Хүн гэдэг бурханы үйлийг хичнээн хэрэгжүүлээ ч элдэв бодолд төөрөлдөн, алдаа дутагдал бүрээ олж анзаарна гэж байдаггүй. Иймд үргэлж өөртөө дүгнэлт хийж, алдаа дутагдлаа ухааран гэмших сэтгэлтэй байх чухал ба үүний үндсэн дээр бурханы үйлийг хэрэгжүүлэх аваас хүний хувьд өсөж хөгждөг хэмээн тус сударт сургажээ.

Давтан хэлэхэд хүмүүс бид үргэлж өөдөө тэмүүлж байдаг учраас л өөрийгөө эргэцүүлэн бодох, гэмших сэтгэл төрдөг. Бүр нарийн яривал гэмших сэтгэл төрнө гэдэг нь бурханлаг чанар ажиллаж байгаагийн шинж, бодисадва хүн болохын баталгаа юм. Ингээд бодохоор өөрийгөө эргэцүүлэн бодож, алдаа дутагдлаа ухааран гэмших нь үнэхээрийн гайхалтай зүйл биш гэж үү.

### Дахин дахин хэрэгжүүлэх

Токиогийн олимпоор ялагдал хүлээсэн нэгэн тамирчин “Алдаагаа олж, засаж залруулан улам өсөж хөгжихийн төлөө хичээх болно” гэж хэлэхийг сонсоод үнэхээр их сэтгэл хөдөлж билээ. Хүний амьдралд өөрийгөө эргэцүүлэхүй ба хөгжил дэвшил хоёр зэрэгцэн оршдогийг ганц энэ жишээнээс гэхэд л харж болохоор байна.

Гэхдээ өөрийгөө ухаарч, засаж залруулна гэхихээд түүнийгээ умартан дахиад л алдаагаа давтан харамсдаг нь мөн л хүний амьдрал билээ. Гэмээ цайруулна гээд амлачихсан юм чинь яасан ч алдаагаа дахин давтаж болохгүй гэж хэтэрхий өөрийгөө шахах юм бол дотор бачуураад ирнэ. Алдаанаасаа ухаарч ойлгосон зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээх, эсвэл шашин шүтлэгтэй хүний хувиар наминчлах үйлд шамдах нь чухал боловч хэт түүндээ баригдах юм бол хэлсэндээ хүрч чадахгүй байгаа өөрийгөө болон өрөөл бусдыг буруутгах сэтгэл төрж болзошгүй.

Иж бүрний билигт бодисадвагийн даяны бүтээл сударт “Нисваанисаасаа бүрэн ангижираагүй байсан ч гэсэн шунал хүсэлдээ автагдахгүй байх хэрэгтэй. Бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэхэд энэ л хамгийн чухал.” хэмээн айлдсан байдаг. Үүсгэн байгуулагч “Өөрийгөө алдаа их гаргадаг, чадвар муутай гэж бодох юм бол түүнийгээ засаж, шинээр эхэлхэд л болно. Энэ жил засаж чадаагүй бол дараа жил заавал засаж залруулна гэж шийдэхэд л болох юм” хэмээн дутуу дулимаг бид бүхнийг дэмжиж зоригжуулдаг байсан.

Сайн үйл хийсэн ч бай, муу үйл хийсэн ч бай хийсэн бүхнээ бурханы өмнө илчлэн сэтгэлээ уудлах аваас сэтгэл угаагдан цэвэрлэгддэг. Тэгээд дахин шинээр эхлэхэд л болох юм. Өөрийгөө эргэцүүлэн бодож, алдаа дутагдлаа ухаарсан гэмшил нь бурханы зам мөрөөр алхахад туслах таяг болж, ийн бага багаар хүн өсөж хөгждөг.

Мөн хүн хийх ёстой зүйлээ хийж байх үедээ бурханд хамгийн ихээр ойртдог гэж сонсож байсан. Иж бүрний билигт бодисадвагийн даяны бүтээл сударт мөн “Хэрвээр наминчлахыг хүсвээс юмс үзэгдлийн бодит төрхийг бясалган суувал зохино” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл өөртөө дүгнэлт хийж, алдаа дутагдлаа ухаарсан бол дараа нь хувиа хичээсэн сэтгэлээсээ ангижирч, аливаа зүйлийг байгаагаар нь хүлээн авч, өдөр бүрийг үр дүнтэй өнгөрүүлэх чухал ажээ.

«Косей» 2021 оны 11-р сарын дугаар

# Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

## Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх


### Байгууллагын үүслээс эдүгээг хүртэл

Рисшо Косей Кай байгууллага одоогийнх шиг том нийгэмлэг болох хүртэл Үүсгэн байгуулагч болоод анхны гишүүд хүнд хэцүү үеүдийг туулсан.

Шашны байгууллагуудад хатуу хяналт тавьдаг байсан дэлхийн 2-р дайны үед Үүсгэн байгуулагч, Мёокоо багш хоёрыг сургаал номоороо ард иргэдийн сэтгэл санааг үймүүлж байна гэх шалтгаанаар цагдаагийн хэлтэс рүү хүртэл авч явж байжээ. Үүсгэн байгуулагч сургаал ном, зааж сургах арга барил нь үнэн зөв болохыг чин сэтгэлээсээ тайлбарласны эцэст тэднийг сэжиглэхээ больж сулласан гэдэг. Үүсгэн байгуулагч хорих байран дахь эрх чөлөөгүй өдөр хоногуудыг “Бас нэгэн төрлийн амьдралын туршлага” гэсэн сэтгэлээр өнгөрүүлж байв.

Мөн тэрээр бурханы номыг хэрэгжүүлж, өөрийн болгохын тулд гэр бүлээсээ тусдаа 10 жил амьдарсан. 1957 онд Мёокоо багштан бурхан болж харамсалтай үйл явдал тохиосон. Рисшо Косей Кай байгууллага ийм хүнд хэцүү үеүдийг туулан хөгжиж дэвшсэн ба эдүгээ олонд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болоод байгаа билээ.

Ингээд 1938 онд үүсгэн байгуулагдсан байгууллагынхаа үүх түүхийг сурч мэдэцгээ.



Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

## Цагаан лянхуа судартай учирсан нь




Үүсгэн байгуулагч 27 насандаа гэрлэж, даршилсан ногооны дэлгүүр ажиллуулж байхдаа Цагаан лянхуа судартай учиржээ.

Нэг өдөр хүүхэд нь өндөр халуурав. Тэр үед “Хүнд хэцүү үе тохиолдвол Арай Сүкэнобү гуайнд очоорой” гэж хэн нэгний хэлж байсныг санан тэднийд очсон нь тэрхүү учралын эхлэл болсон юм.

Арай багшийн зөвлөснөөр бурхан тахилын өмнө Цагаан лянхуа судрыг унштал залбирлыг нь сонсов уу гэлтэй хүүхдийнх нь халуун буурав. Түүнээс хойш Үүсгэн байгуулагч Цагаан лянхуа судрыг судалж эхэлсэн гэдэг.

### Бяцхан мэдлэг

Үүсгэн байгуулагч 1930 онд Абэ Саи (хожим Наоко гэдэг номын нэртэй болсон) гэдэг эмэгтэйтэй гэрлэсэн. Тухайн үед түрээсийн байранд амьдран, даршилсан ногооны дэлгүүрт ажиллаж байв. Дараа нь Токиогийн Нагано Хонго гудамжинд “Ракку-Я” хэмээх өөрийн дэлгүүртэй болжээ.



## Олон улсын хэлтсийн даргын булан

### Өөртөө дүгнэлт хийх нь эерэг хандлага

Нивано ерөнхийлөгчийн Лянхуан гурамсан судрын тайлбар дуусах дөхөж байна. Энэ сар болон дараагийн сард төгсгөлийн Наминчлах судрын талаар айлдана.

Энэ сарын дугаарын “Өөрийгөө эргэцүүлэхүйн учир” гэсэн гарчигийг хараад шууд л оны эхний айлдвар сэтгэлд минь буусан. 2021 оны айлдвар “Өөрийгөө эргэн харж, шинийг хийж бүтээцгээ” гэсэн гарчигтай байсан ба “Корона бол хүн төрөлхтний хувьд хамгийн чухал зүйл юу болохыг дахин тунгаан бодох боломж юм” хэмээн ерөнхийлөгч бидэнд өөрийгөө эргэн харахыг сануулсан.

Түүний ачаар миний хувьд юм л бол өөрийнхөө сэтгэл рүү өнгийн хардаг болсон юм шиг санагдаад байгаа. Харин та бүхэнд ямар нэгэн өөрчлөлт гарсан уу?


Гэмээ наминчлах гэхээр сөрөг, бараан дүр зураг буудаг хэдий ч ерөнхийдөө нэгдүгээрт “Алдаагаа ухамсарлах”, хоёрдугаарт “Тэр алдаагаа засахаа амлах”, гуравдугаарт “Зөв замд орохын төлөө хичээх” гэсэн үг юм.

Тэгвэл сүсэг бишрэлт хүмүүс бидний хувьд ”наминчлах” гэдэг ямар үйл юм бол? Өөрийгөө эргэцүүлэн бодож, энэ үйлийг эерэгээр хүлээн авч хэрэгжүүлэн сэтгэлээ цэгцэлж, энэ сард ч гэсэн “Эхлээд бусдын төлөө” гэсэн бодьсадвагийн үйлийг хэрэгжүүлцгээ.

Акагава Кэйичи



# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA  
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633  
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA  
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA  
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567  
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA  
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA  
 TEL: 1-650-359-6951 Email: [info@rksf.org](mailto:info@rksf.org)

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA  
 TEL: 1-212-867-5677 Email: [rkny39@gmail.com](mailto:rkny39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA  
 TEL: 1-773-842-5654  
 Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA  
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA  
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303  
 Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA  
 TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA  
 URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA  
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567  
 Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org)  
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA  
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA  
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745  
 Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)  
 URL: <http://rksabuddhistcenter.org>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA  
 TEL: 1-253-945-0024 Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)  
 URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil  
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377  
 Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>

**在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai**  
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

**在家佛教韓國立正佼成會釜山支部**

**Korean Rissho Kosei-kai of Busan**  
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

**社團法人在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei**  
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

**台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan**  
台灣台南市東區崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

**Rissho Kosei-kai South Asia Division**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

**Rissho Kosei-kai Society of Kolkata**

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

**Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,  
West Bengal, India

**Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center**

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,  
Bihar, India

**Rissho Kosei-kai of Patna Dharma Center**

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

**Rissho Kosei-kai of Central Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,  
New Delhi 110060, India

**Rissho Kosei-kai of Singapore**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai of Phnom Penh**

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,  
Phnom Penh, Cambodia

**RKISA Rissho Kosei-kai International of South Asia**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

**Rissho Kosei-kai of Bangkok**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

**Rissho Kosei Dhamma Foundation**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

**Rissho Kosei-kai Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL: 880-2-41360470

**Rissho Kosei-kai Mayani**

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Damdama**

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Satbaria**

Village: Satbaria Bepari Para, Chandanail, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Chendhirpuni**

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai Raozan**

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai Laksham**

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

**Rissho Kosei-kai Dhaka North**

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

**Rissho Kosei-kai Cox's Bazar**

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

**Rissho Kosei-kai Patiya**

**Rissho Kosei-kai Ramu**

**Rissho Kosei-kai Aburkhill**

**Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroov-1, Chingeltei district,  
Ulaanbaatar 15160, Mongolia  
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia  
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Erdenet**

Please contact Rissho Kosei-kai International

**Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

**Rissho Kosei-kai of Paris**

**Rissho Kosei-kai of Venezia**

**Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK  
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>  
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>  
Twitter: [https://twitter.com/rkuk\\_official](https://twitter.com/rkuk_official)  
Instagram: [https://www.instagram.com/rkuk\\_official](https://www.instagram.com/rkuk_official)

**Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)**

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>